



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/894

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалт, Аймгийн агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/246 дугаар тушаалаар 400,000,000 төгрөг /дөрвөн зуун сая/, 2019 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн А/117 дугаар тушаалаар 800,000,000 төгрөг /найман зуун сая/-ийг аймгийн агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд зарцуулах эрхийг аймгийн Засаг даргад тус тус шилжүүлсэн бөгөөд уг санхүүжилтээс хэвлэл мэдээлэл, сурталчилгааны ажилд зориулан 17 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 17 000 000 төгрөг /арван долоон сая/-ийг Агаар, орчны бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, ажлын тоо хэмжээ зэргийг үндэслэн "Байгаль орчин аялал, жуулчлалын сайдын тушаалаар эрх шилжин ирсэн зардал"-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3. "Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа"-ны ажил гүйцэтгэх аж ахуйн нэгжүүдийг хавсралтаар баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




Б.ДҮГЭРЖАВ

Zax A/894 Ch

02 04357

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 23-ны өдрийн
А/894 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН
ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ
АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ЖАГСААЛТ

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Төслийн нэр	Олгох санхүүжилт /төгрөг/
1.	Сова медиа групп ХХК	Контент нийлүүлэх	10,000,000
2.	Соёмбо принтинг ХХК	Сэтгүүл хэвлэх	7,000,000
	Нийт дүн		17,000,000

-оОо-